



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/30

Сант сум

Үхсэн малын сэг зэм устгах,  
халдваргүйжүүлэх ажлын хэсэг байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.3, 7.4, 7.5, 7.12, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны А/34 дугаар тушаал, Монгол Улсын Байгаль орчин аялал жуулчлалын сайдын "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/165 тоот захирамж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн малын гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчин гарах, тархахаас урьдчилан сэргийлэх, өвөлжилт, хаваржилтын хүндрэл болон өвчний улмаас хорогдсон мал, амьтны сэг зэм цуглуулж устгах, бэлчээр бууц, хашаа хороо, уст цэг усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх ажлыг шуурхай, чанартай байгуулах зорилгоор "Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян"-ыг сумын хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 05 сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга :

А.Одхүү

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Г.Анхбаяр

(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Ч.Төгсбаатар

(Хушаат багийн байгаль хамгаалагч)

Ж.Лхагважаргал

(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

Г.Ууганцэцэг

(Санхүү албаны дарга)

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн 1-р багийн Засаг дарга)

Б.Золбаяр

Боловсруулсан: *Т. Ахбаяр*  
Хянасан: *С. Амарпилс*  
Хувь: *2*  
Огноо: *2011.08.10*

( Хушаат 2-р багийн Засаг дарга)  
О.Лхагвасүрэн  
(Сантбаянхайрхан МЭҮН-н Захирал)  
Ө.Ганбаатар  
( Бошгын булаг ХХК-н Захирал)

2.Ажлын төлөвлөгөө гаргаж үйл ажиллагааг хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Мал амьтны хашаа хороо, худаг уст цэг, булаг шанд, гол горхины орчныг цэвэршүүлж, өтөг бууц, хөрзөнг гадагш гаргаж хураах, хорогдсон мал, амьтны сэг зэм цуглуулж, устгах ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах.

4.Мал,амьтны сэг зэмийг устгах ,халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах ажиллах хүч, унаа тээврийн болон бусад зардлын төсвийн тооцоог гаргаж шийдвэрлүүлэхийг Санхүү албаны дарга (Г.Ууганцэцэг)-д даалгасугай.

5.Тус ажилд суманд дүйцүүлэх цэргийн алба хааж байгаа алба хаагчдыг дайчилж ажиллахыг багийн Засаг дарга (Л.Сэлэнгэсайхан), (Б.Золбаяр) нарт үүрэг болгосугай.

6.Сумын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийх дамжин өнгөрөх чиглэл, хугацааг тогтоох, шилжилт хөдөлгөөн хийх явцад зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг, зэмийг цуглуулах, устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг зааврын дагуу чанартай хийлгэж,хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Анхбаяр)-д даалгасугай.

7.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Б.Мөнх-эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР